

АРДЧИЛЛЫН III ЧУУЛГАН
“ЧӨЛӨӨТ, ХАРААТ БУС ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АРДЧИЛАЛ ДАХЬ ҮНЭ ЦЭНЭ”
Улаанбаатар хот, 2017 он 06 дугаар сарын 13

“ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ”

Др. , проф. инженер Дагмар Шипански
ХБНГУ-ын Христийн Ардчилсан Холбоо Намын
Холбооны Удирдах Зөвлөлийн гишүүн

Эрхэм хүндэт хатагтай ноёд оо,

Конрад-Аденауэр-Сангаас зохион байгуулж буй өнөөдрийн хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд мэнд хүргэе. Өнөөдрийн хурлын сэдэв нь өнөө цаг үед маш чухал юм, учир нь хэвлэл мэдээллийн ач холбогдол бидний амьдралд улам нэмэгдэж байна. Ийм цаг үеэ олсон сонирхолтой сэдвээр зохион байгуулж буй хурал дээр илтгэл тавих боломж олгосон Конрад-Аденауэр-Сангийханд талархал илэрхийлье.

Хүндэт хатагтай ноёдоо,

Сүүлийн жилүүдэд Монгол Улс анхаарал татахуйц ардчилсан нийгмийг бий болгож, энэхүү байр сууриа Азийн бүс нутагт баталгаажуулж чадсан. Та бүхэн эдийн засгийн болон нийгмийн маш том өөрчлөн байгуулалтуудыг хийсэн мөн хэвлэл мэдээллийн ач холбогдолыг ойлгосон. Тийм болохоор энэ хурал та бүхний цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой юм. Би Германы зүүн хэсгээс гаралтай, 1990 он хүртэл хэвлэл болон мэдээллийн салбар нь төрийн номлол дор байсан. Дэлхий дахинд болж байгаа үйл явдлын талаар төрийн хяналтанд байдаг өрөөсгөл хандлагатай мэдээлэл түгээдэг байсан. Үүгээр хүмүүсийг нийгмийн ерөнхий хөгжлөөс хязгаарлаж, философийн шинэлэг бодол санаанаас ангид байлгаж, оюун ухааны өрөөсгөл хандлагатай байлгадаг байсан. Дэлхийд болж байгаа бүх үйл явдлуудыг нэг талаас буюу өөрсдийн үзэл суртлын талаас тайлбарлаж, бодит баримт мэдээллийг санаатайгаар өөрчилж хуурамчаар мэдээлдэг байсан. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үед Та бүхэн ч гэсэн ЗХУ-ын Коммунист намын хяналтаар явуулдаг хэвлэл мэдээллийн бодлого дор зовж байлаа. Ийм хэвлэл мэдээллийн орчинд Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын ард иргэд нь хэвлэл мэдээллийхэнд итгэх итгэлээ алдсан. Үүний зэрэгцээ хэвлэл мэдээлэл ялангуяа зурагт телевизүүд өөрсдийн мэдээллэр дамжуулан ямар их эрх мэдэлтэй байгаа нь тодорхой болсон юм. 1989 оны тайван жагсаал цуглаан болон хана нураах үйл явцын гол төлвийг барууны хэвлэл мэдээллийн сурвалжлагын нөлөөн дор хийгдсэн. Бид Зүүн Германы олон хотод тайван жагсаал цуглаан болж байгааг „Дайсны сувгаар“ харж, иргэний хөдөлгөөний уриаг сонсож мөн Германы Дотоод яам руу дайрахыг дэлгэцээр харсан. Бид хэвлэл мэдээллийн эрх мэдлийг мэдэрсэн бөгөөд аливаа орны улс төрийн амьдралд ямар ач

холбогдолтойг нь ойлгосон. Тийм болохоор бид 1990 онд нэгдсэнийхээ дараа шинээр баталсан Үндсэн хуулиндаа хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хуулиараа баталгаажуулсан. Тюринген мужийн Үндсэн хуулийн 11-р зүйлд дараах байдлаар тодорхойлсон:

- 1. Хүн бүр чөлөөтэй өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, түгээх мөн нийтийн эх үүсвэрээс мэдээлэл авах эрхтэй.*
- 2. Хэвлэл мэдээлэл, радио, телевиз, кино болон бусад бүх төрлийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангана. Цензурийг зөвшөөрөхгүй.*
- 3. Эдгээр эрх нь ерөнхий хууль тогтоомжийн заалт, Хүүхэд, залуучуудыг хамгаалах тухай хууль болон хувь хүний нэр төрийг хамгаалах тухай хуулиудаар хязгаарлагдана.*

Эрхэм хүндэт хатагтай, ноёдоо,

Үүгээр хэвлэл мэдээллийн үүрэг мөн эрх нь хуулиар хамгаалагдсан байдаг байна, гэхдээ өдөр тутмын амьдралд энийг юу гэж ойлгох вэ? Хувь хүний хувьд эрх чөлөө гэдэг нь олон үйлдлээс сонголт хийх боломжтой байхыг хэлнэ. Хувийн эрх чөлөө гэдэг нь өөрийгөө ухамсарлахуйг хэлэх үү? Эрх чөлөө гэдэг нь илүүтэйгээр хариуцлагаа ухамсарлах чухал нөхцөл нь биш үү? Эрх чөлөө нь мөн өөрийн үйлдлийн үр дагаварыг өөрийн болон бусдын төлөө ажиглах гэсэн үг юм. Эрх чөлөө гэдэг нь үүрэг хариуцлага ямарч болзолгүй хүлээн зөвшөөрөхийг хэлж байгаа юм. Энэ бүх зүйл салшгүй холбоотой, үгүй бол эцсийн дүндээ хувиа хичээсэн байдал давамгайлах болно. Эрх чөлөө болон хариуцлага нь нэг нэгнийгээ нөхдөг зарчим гэдгийг бидэнд олон зуун жилийн турш Европын хүндэт жаяг гэж заадаг. Эрх чөлөө болон хариуцлагын энэхүү дотоод холбоос нь улс төр болон хэвлэл мэдээллийн суурь зарчим юм. Улс төрчдийн хувьд хүн амынхаа сайн сайхан байдлыг хангахын тулд хот болон тосгодыг олон улсын хэмжээнд хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг хэлж байгаа юм. Улс төрчдийн ажлыг ард иргэд нь дүгнэдэг. Сонгуулийн өдөр болгон маш мэдрэмтгий сейсмограф гэж хэлж болно. Энэ өдөр амласан зүйлүүдийг бодит байдалтай хэр нийцэж байгааг хардаг. Ард иргэдийн улс төрчдөд итгэх итгэл алга болсон бол тэд сонгодоггүй. Хэвлэл мэдээллийнхэн энэ эгзэгтэй мөчид оролцдог бөгөөд тэдэнд мэдээлэх болон үнэлэх эрх чөлөө байдаг. Гэхдээ тэд бас өөрсдийн мэдэгдэл, үзүүлж буй нэвтрүүлгүүд, нийгэмд үзүүлж буй нөлөөндөө хариуцлага хүлээдгээ санаж байх хэрэгтэй. Тэднийг сонгуулиар сонгодоггүй болохоор хэвлэл мэдээллийнхэн өөрөө өөрийгөө хянах хяналтыг бий болгосон.

Улс төр-Хэвлэл мэдээлэл-Ард иргэд гэдэг харилцан тоглолт бөгөөд энэ нь итгэлцэл дээр тулгуурлах ёстой. Дахин тодотгож хэлэхэд: Улс төр бол бодлого боловсруулах ёстой, харин хэвлэл мэдээлэл нь боловсруулах үйл явцыг нь бий болгож олон нийтийн төлөө дагалдаж ажиглах ёстой. Улс төр хэвлэл мэдээлэл нь нэг нэгэндээ хэрэгтэй.

Улс төрийнхөн нь мэссэж өгөхийг хүсдэг – хэвлэл мэдээлийнхэн мэдээлэл өгөхийг хүсдэг бөгөөд тэдэнд мэдээлэл хэрэгтэй байдаг. Мэссэжийг хувиргахын тулд хоёр талын харилцан итгэлцэл байх ёстой. Хэт нэг талын, зөвхөн шүүмжилсэн, сөрөг мэдэгдлүүдийг хэтрүүлэн гаргах нь итгэлцлийг эвддэг бөгөөд мэдээлэл авах боломжуудыг хязгаарладаг. Улс төрийн болон хэвлэлийн эрх чөлөөг улс төрч мөн сурвалжлагч болгон өөрийн хувийн хариуцлага гэдгийг ухамсарлах ёстой нь миний хувьд их чухал байна. Ард иргэдийнхээ иж бүрэн, бодит мэдээлэл авах эрх болон Ардчилалын сайн сайхны төлөө оролцогч талууд орчноо идэвхитэй хөгжүүлэх ёстой. Зөвхөн ингэж байж л ард иргэд нь хэвлэл мэдээллийн мэдээнд итгэдэг болно. Харамсалтай нь өнөөдөр хэвлэл мэдээллийнхний дунд „Муу мэдээ бол сайн мэдээ” гэх хандлага хүчтэй хэвээр байна. Гэхдээ энэ нь ард иргэдийн төлөө юү? Өдөр тутмын амьдрал, нэг хүний сайн сайхан байх, үе удмын асуудлыг шийдэх, сурах боломжууд, эрүүл хөгжил бас чухал биш үү? Гарч буй мэдээллүүд нь бидний энгийн амьдралын бүх асуудлуудыг харуулж чадаж байна уу? Өөр гадны мэдээлүүд, дуулиан шуугиантай асуудлууд, сүүлийн үед харамсалтай нь террорист халдлагуудын талаарх мэдээллүүд давамгайлж байгаа юм биш үү!

Мэдээж хэвлэл мэдээллийн өргөн хэрэгслээр мэдээлэл авч олон талаас нь дүгнэсэн дүгнэлтүүдийг уншиж байгаа хүмүүс нь илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй байж л жинтэй шийдвэр гаргана. Хүмүүсийн санал бодол болон уур амьсгалд самбаруудын гарчиг хэрхэн нөлөөлдгийг бид мэдээж дутуу үнэлж болохгүй. Ихэнх хүмүүс товч мэдээлэлд дуртай байдаг. Үүнд хэвлэл мэдээллийнхэн анхаарч байх хэрэгтэй. Гэхдээ нэг дүрмийг байнга мартажгүй байх нь чухал: Бидэнд цогц, бүхий л талаас нь дүгнэсэн, ултай суурьтай, эерэг болон сөрөг талыг нь агуулсан мэдээлэл хэрэгтэй. Хэвлэл мэдээллийнхэн өөрийн сонголт, бичилтийн хэлбэр болон далайцаараа ард иргэдийн үзэл бодлоо бүрдүүлэх үйл явцад тодорхой нөлөө үзүүлдэг. Зарим сэдвүүдийг хоёр минутын дотор телевизийн ярилцлагаар бүрэн толилуулах боломжгүй байдаг. Бидний ертөнцөд асуудлууд харилцан холбоотой, цогц байдаг болохоор ганц дан түлхүүр үгээр шийдчих боломгүй юм. Хамгийн сүүлийн жишээ бол: Доналд Трампын сонгууль байлаа. Тэрээр цогц асуудлуудад маш энгийн хариулт өгсөн, гэхдээ энэ нь сонгуулийн дараа шинэ проблем буюу хүндрэлтэй асуудлуудыг бий болгосон. Үүнээс болоод би дараах асуултыг дэвшүүлмээр байна. Хүндрэлтэй цогц асуудлуудыг бид ирээдүйд ард иргэддээ энгийнээр яаж тайлбарлах вэ? Хэвлэл мэдээлэл болон улс төрийн хэлэлцээрт ард иргэдээ идэвхитэй оролцуулах ямар боломжуудыг бид шинээр бий болгох ёстой вэ? Хэрэв бид энэхүү боломжуудыг нээж өгөхгүй бол итгэл алдагдана. Энэ нь твиттер дээр хувь хүмүүсийн бичиж буй шүүмжтэй дүгнэлтүүдээс харагдаж байна. Германд бүр ПЕГИДА нэртэй („Эх оронч европчууд барууныг исламчлахын эсрэг”) жагсаал цуглаан болсон.

Гол агуулга нь „Худалч хэвлэл” мөн Германд хамгийн том асуудал болоод байгаа цагаачдын асуудлыг шийдэж чадахгүй байгаагаас улбаалаад улс төрчдөд итгэл алдсантай холбоотой ийм жагсаал цуглаан болов. Хэвлэл мэдээлэл болон улс төрд итгэл алдах нь хоорондоо нягт холбоотой үйл явц бөгөөд энэ нь эрх чөлөөт, ардчилсан нийгмийн амин судас болох ардчилалд итгэх итгэлийг үгүй хийдэг. Тийм болохоор улс төрд шийдвэр гаргах үйл явцын нарийн хамаарлуудыг, үйл явц зааг хязгааруудыг нь харуулж мөн гаргасан шийдлүүдийг нь харилцан буулт хэмээн харуулах шаардлагатай. Тийм болохоор аливаа мэдээлэл гаргахдаа эхлээд гол хуулийн заалтуудыг нь тайлбарлаад дараа нь сөрөг хүчинд үг хэлэх эрхийг нь олгох явдал чухал. Гэхдээ жишээ нь Эрүүгийн тухай хуулинд гэмт хэрэгтэй илүү хатуу тэмцэхээр зохицуулалтууд оруулж өөрчлөх гэж байгаа бол эхлээд товч тайлбарлаад дараа нь сөрөг хүчинд шүүмжлэхэд нь илүү цаг өгвөл, ард иргэд нь итгэлгүй болж, асуудлын голыг нь ойлгохгүй болно. Ийм тохиолдолд мэдээллээ яаж хүргэх вэ гэдгийг сайтар бодох хэрэгтэй. Олон давтсанаар энэ нь хүлээн зөвшөөрөгдсөн үнэн гэдгээр асуудалд бас хандаж болохгүй. Ярилцлагын нэвтрүүлгүүдэд асуудлыг гаргаж тавьж байгаа нь зохих хэмжээнд байна уу? Зөвхөн Асуулт тавьж байгаа хүмүүсийн сэтгэхүйн хэмжээнд асуудлыг харуулж байна уу? Улс төрч болон ард иргэдийн шууд харилцах ямар нэмэлт боломжуудыг хэвлэл мэдээллийнхэн бий болгох ёстой вэ? Өнөөгийн социал ертөнцийн хөгжил нь энэхүү шинэ замуудыг зааж өгч байна.

Өгсөн мэдээллийг дүгнэхэд хэрэглэгчидээс хэвлэл мэдээллийн мэдлэг чадвартай байхыг шаардаж байна. „Хуурамч мэдээллийг” үнэн бодит мэдээллээс яаж ялгаж салгаж болох вэ? „Үзэл бодлыг үйлдвэрлэх” гэж юү вэ, баримт гэж юү вэ? Олон нийтийн хэвлэл мэдээллийн орчин нь хууль эрх зүйгээр зохицуулагдсан байдаг бол, социалын сүлжээ нь харин ямарч зохицуулалтгүй, ямарч хил хязгаар байхгүй байна. Олон хүмүүст энэ нь боломжийг бий болгодог ч, нөгөө талаасаа маш их аюулыг дагуулдаг.

Би жишээ болгож Тюринген мужийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хууль эрх зүйн орчингоос иш татмаар байна. Тюринген мужийн Үндсэн хуулийн 12-р зүйлд ингэж заасан байдаг.

1. Тухайн муж нь олон нийтийн радио мэдээллийн суурь хангамжийг бий болгоно, хувийн болон төрийн радио телевизүүдэд мэдээллээ тэнцвэртэй түгээх боломжуудаар хангана.
2. Олон нийтийн радио телевизийн хяналтын хороо мөн хувийн радио телевизийн ижил төстэй хороонд улс төрийн, үзэл суртлын болон нийгмийн бүлгийн оролцоог хуулинд заасны дагуу хангасан байх ёстой.

Эдгээр хороод нь өөрсдийн хариуцлагаа ухамсарласан байдаг болохоор энэ нь хэвлэл мэдээллийн чанарын баталгаа болж өгдөг. Ард иргэдээ баталгаатай мэдээллээр хангах ижил төстэй суурь зохицуулалтыг Та бүхэн ч гэсэн Монголд бий болгосон гэсэн. Энэхүү бий болгосон зүйлээ өөрийн орны ардчиллаа бэхжүүлж, бататгахын тулд сайн хамгаалж арчилаарай. Ардчилал бол дахин дахин шинээр эргэн харж, жишээ нь улс төр, хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмээрээ харилцан эргэн харах ёстой хэврэг засаглалын хэлбэр юм. Хэдэн мянгаар санал бодлоо чөлөөтэй солилцох, өөр оронд байгаа хүмүүсийг хооронд нь холбосон сошиал сүлжээний хөгжил нь ямар зохицуулалтуудыг бий болгохыг шаардаж байна вэ? Хараал, хурамч мэдээлэл болон сошиал ийн мэдээллийг хянадаг программууд энэхүү ертөнцөд үзэл бодлыг мөн хэлэлцүүлгүүдийн явцыг гажуудуулж удирдаж байна. Бид санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг баймаар байна, гэсэн хэдий ч хүчирхийлэл, хувь хүмүүсийг доромжлох, гүтгэлэг, кибер хавчлага болон мэдээллийг гажуудуулахыг тэвчиж болохгүй. Эрх чөлөөт нийгэмд хуулиар зохицуулаагүй орчин гэж байж болохгүй, интернет мөн адил. Үүний зэрэгцээ нэг хүн ч гэсэн энэ их мэдээллийн урсгалыг боловсруулж, жинхэнэ мэдээллийг хуурамчаас ялгаж, мэдээ болон комментийг ангилж (чанартай хэвлэл мэдээллийн сувгууд өөрсдөө үүнийг хийчдэг) сурах хэрэгтэй байна. Үүний тулд хэвлэл мэдээллийн мэргэжлийн цогц ур чадварыг бий болгох шаардлагатай. Өөрийн үзэл бодолдоо итгэдэг хүн, улс төр болон хэвлэл мэдээллийнхэнд итгэдэг болдог, тэдний ажлыг ч шүүмжтэй дүгнэж чаддаг. Улс төр, хэвлэл мэдээлэл болон ард иргэдийн харилцаа өөрчлөгдөж байна, маш хурдан хөгжиж байна. Энэхүү үйл явцыг бид маш идэвхитэй төлөвшүүлэх, хэт их мэдээллийн хил хязгаарыг тогтоох мөн мэдээллээр сайн хангах төрийн бодлого хэрэгтэй байна. Үүнд өнөөдрийн арга хэмжээ хувь нэмрээ оруулна гэж найдаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа!